

ЗИМБАБВЕГААС МЭНДЧИЛЖ БАЙНА!

Зимбабве улс нь Өмнөд Африкт байдаг.
16,500,000 гаруй хүн энд амьдардаг.

ГАЙХАЛТАЙ ХҮРХРЭЭ

Зимбабвед байдаг Виктория хүрхрээ бол дэлхийн хамгийн том хүрхрээ юм. Хүрхрээний чимээ 40 гаруй км хол зайнаас ч сонсогддог гэнэ шүү!



ГАЙХАЛТАЙ АМЬТАД

Зимбабвед маш олон бэлчээрийн тал бий. Тэнд амьдардаг амьтдын зарим нь арслан, усны үхэр, анааш, гөрөөс, заан юм.



БОШИГЛОГЧИЙН АЙЛЧЛАЛ

2018 оны 4-р сард ерөнхийлөгч Нэлсон, Нэлсон эгч хоёр Зимбабве улсад айлчилсан. Хэдэн зуун хүүхэд тэдэнд "Би Бурханы хүүхэд" дууг дуулж өгөв.



Ливүкилэ!

Энэ нь дэбэли хэлээр "Өглөөний мэнд!" гэсэн утгатай.

ХЭЛ

Зимбабве албан ёсны 16 хэлтэй. Шона, дэбэли, англи хэл гээд цөөн хэдийг нь л нэрлэе!



ҮЙЛ
АЖИЛЛАГАА

Зааны гар урлал

Зимбабве нь зааны тоо толгойгоороо дэлхийд хоёрт ордог!

1. Толгой хийх нэг том дугуй, чих хийх хоёр жижгэвтэр дугуй цаас хайчил. Тэгээд хоёр чихийг нь толгойд нь наагаарай.
2. Биеийг нь хийх урт тэгш өнцөгт цаас хайчилж, нааш цааш нь нугална.
3. Зааны хоёр соёо хайчил.
4. Одоо заандаа нүд, мөн инээмсэглэл нэмж зураарай. Дараа нь соёо болон их биеийг наагаарай!

ЖОР



Муриво Анэдови (Самрын тостой ногоонууд)

Муриво Анэдови нь Зимбабвегийн үндэсний хоол юм. Энэ хувилбарыг туршаад үзээрэй!

1. **1 ширхэг сонгино** дөрвөлжин хэрчээд, хайруулын таваг дээр **тосонд** 3–5 минут болго. **2 ширхэг улаан лооль** дөрвөлжин хэрчээд, хайруулын тавагт хий. Дахин 3–5 минут болгоорой.
2. **10 аяга (2400 мл) бууцай** (эсвэл өөрийн сонгосон навчит ногоо) хэрчээд нэмж хийгээрэй. Ногоонуудаа 5 минут жигнэ.
3. **2 халбага (30 мл) самрын тос**, **1/4 аяга (59 мл) ус**, **1/2 цайны халбага (2.4 мл) саримсны нунтаг** нэмээд сайтар хутгаж, **давс** нэмж амтална.